



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 08 сарын 03 өдөр

Дугаар 11676

Мандалговь

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт
шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 /а/, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.8, 4.5.9, 4.5.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Малын гоц халдварт шүлхий өвчин гарч Гурвансайхан суманд оношлогдсон, Өлзийт суманд сэжигтэй голомтууд бий болж буй тул дээрх сумдыг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

Хоёр. Малын гоц халдварт өвчин гарсантай холбогдуулан Гурвансайхан, Өлзийт, Сайнцагаан сумдад малын шилжилт хөдөлгөөн, найр, морины уралдаан зэрэг олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг хориглох, урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээ авч ажиллахыг дээрх сумдын Засаг дарга Э.Загдсүрэн, И.Эрдэнэбилэг, Р.Мөнхтогтох нарт даалгасугай.

Гурав. Шүлхий өвчин гадагш тархахаас хамгаалж хорио цээрийн дэглэм сахиулах, пост гарган хамтарч ажиллахыг Онцгой байдлын газар /Я.Алтанхундага/, Цагдаагийн газар /Б.Очирдорж/, Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/, Хүнс, хөдөө аж ахуйн газар /Б.Мөнхжаргал/, Гурвансайхан, Өлзийт, Сайнцагаан сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

Дөрөв. Захирамжийн биелэлтийг хангуулж, нэгдсэн удирдлагаар ханган, үр дүн, ажлын явцыг танилцуулж байхыг Онцгой комиссын орлогч дарга /Я.Алтанхундага/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Ж.МӨНХЧУЛУУН



0220771